

/2013 оны 12 дугаар сарын 18-ны өдөр, 13.00 цаг, Төрийн ордон, Б-танхим/

ХӨДӨЛМӨРИЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ БОДЛОГО, АРГА ХЭМЖЭЭ

Өнөөдөр Монгол Улсын нийт хүн амын 67.2 хувийг хөдөлмөрийн насны хүн ам эзэлж байгаагаас 57 хувь нь 15-34 насныхан, 31 хувь нь 35-49 насныхан, 12 хувийг 50-59 насныхан эзэлж байна.

2013 оны 3 дугаар улирлын байдлаар хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 92.4 хувьтай, улсын хэмжээнд 1086.5 мянган хүн ажил эрхэлж байгаагийн 33 хувь нь ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, 13 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, 8 хувь нь барилга, 7 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 7 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагаа болон 32 хувь нь эдийн засгийн бусад салбаруудад ажиллаж байна. Аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтсүүдэд 42.9 мянган ажилгүй иргэн бүртгэлтэй байгаагаас 0.7 хувийг магистр, доктор, 28.4 хувийг дипломын болон бакалаврын, 8.1 хувийг тусгай мэргэжлийн дунд, 6.2 хувийг техникийн болон мэргэжлийн, 43.2 хувийг бүрэн дунд, 13.4 хувийг суурь, бага боловсролтой болон боловсролгүй иргэд эзэлж байгаа бөгөөд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 63.6 хувь нь 15-34 насны залуучууд байна.

Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн 84.7 хувь нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан, 9.4 хувь нь сургууль төгссөн, 4.2 хувь нь шилжин суурьшсан зэрэг шалтгаанаар ажил эрхлээгүй байна.

Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн төлөв байдлаас харахад ажиллах хүчний ур чадварын тэнцвэргүй байдал, ажил олгогчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн ажиллах хүчний дутагдалтай байгаа нь төрийн зүгээс зайлшгүй анхаарах асуудал болж байна.

Хөдөлмөрийн яамнаас хөдөлмөрийн салбарын бодлогыг эдийн засаг, нийгмийн хүрээний бодлоготой нягт уялдуулан хэрэгжүүлж, ажиллах хүчний оролцооны түвшинг өсгөх, ажилгүйдлийг бууруулах бодлогыг хэрэгжүүлж улмаар хүн амын амьжиргааны түвшинг өсгөх зорилго тавин ажиллаж байна.

Хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний ур чадварыг хөгжүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хөдөлмөрийн зах зээлийн идэвхитэй бодлогын арга хэмжээ хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хүртээмж, хамрах хүрээг өргөжүүлэх гэсэн харилцан уялдаа бүхий бодлогын арга хэмжээ бүхий “Ажилтай, орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Мөн иргэдийг ажилтай, орлоготой болгох, хөдөлмөрийн зах зээлийн идэвхитэй бодлогыг онцлог бүлгүүд, хөдөлмөрийн зах зээл дэх хүн амын эмзэг хэсэгт чиглүүлсэн дараахь хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хувиараа болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр;
- Ажил олгогчийг дэмжих хөтөлбөр;
- Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр;

/2013 оны 12 дугаар сарын 18-ны өдөр, 13.00 цаг, Төрийн ордон, Б-танхим/

- Хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг зохион байгуулах хөтөлбөр;
- Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр;
- 40-өөс дээш болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр;
- Эзэнтэй Монгол хөтөлбөр.

Дээр дурьдсан хөтөлбөрүүдийн хүрээнд хөдөлмөрийн зах зээлийг идэвхижүүлэх, ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлэх, ажил олоход хүндрэлтэй, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвар сул байгаа хэсэг бүлгийг дэмжин ажиллах, хөдөлмөрлөх, орлого бий болгох үйл ажиллагаанд идэвхитэй оролцох хөшүүргийг бий болгох, урт хугацаагаар ажилгүй байгаа зэрэг ажил олоход хүндрэлтэй иргэдэд түр ажлын байр бий болгон орлогоор дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж, тодорхой үр дүн гарч байна.

Тухайлбал, “Ажил олгогчийг дэмжих” хөтөлбөрийн үр дүнд нийт 104 аж ахуйн нэгж, байгууллага 297 ажил олоход хүндрэлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангасан байна. Энэхүү хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй 29 иргэн, 6 сараас дээш хугацаагаар ажилгүй байсан 260 иргэн, хорих ангиас суллагдсан 5 иргэн, хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн 3 иргэн тус тус хамрагдсан байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд 2163 ажлын байр болон аж ахуй эрхлэхийг хүссэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 986 сая төгрөгийн санхүүжилт бүхий 883 төслийг дэмжиж, хэрэгжүүлснээр 1295 байнгын ажлын байр бий болжээ.

Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд ажил олоход хүндрэлтэй иргэдэд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, сэтгэл зүйн болон төлөвшлийн сургалт явуулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг тусгайлсан арга хэмжээг зохион байгуулж байгаа бөгөөд энэхүү хөтөлбөрт нийт 1927 иргэн хамрагдсан байна. Эдгээр иргэдийн 15,5 хувь буюу 299 нь хөгжлийн бэрхшээлтэй, 16.3 хувь буюу 314 нь хорихоос суллагдсан, 0,4 хувь буюу 8 нь асрамжийн газраас гарсан, 27,1 хувь буюу 523 нь 6 сараас дээш хугацаагаар ажилгүй байсан, 33,3 хувь буюу 641 нь нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны чадвартай иргэд, 7,4 хувь буюу 142 нь сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд тус тус эзэлж байна.

Ажиллах хүчний мэргэжлийн ур чадвар, чадамжийг дээшлүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй “Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах” хөтөлбөрийг үйлдвэрлэл дээрх сургалт, мэргэжлийн болон давтан сургалт, явуулын болон зайны, шавь сургалт гэсэн хэлбэрээр явуулж байгаа бөгөөд сургалтад нийт 15750 иргэнийг хамруулж мэргэжлийн ур чадвар олгосон байна.

Залуу малчин өрхийг малжуулах, өрхийн гишүүдийг аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулах, зөвлөгөө мэдээлэл өгөх, мал аж ахуйн материаллаг баазыг нь бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 18 аймгийн 90 сумын 469 залуу малчин өрхийг хамруулав.

/2013 оны 12 дугаар сарын 18-ны өдөр, 13.00 цаг, Төрийн ордон, Б-танхим/

Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх, эрүүл, аюулгүй, хоггүй эко орчин бүрдүүлэх “Эзэнтэй Монгол” хөтөлбөрийн хүрээнд 508 ногоон ажлын төслийг хэрэгжүүлж, 114 иргэдийн бүлэг, 232 нөхөрлөл, хоршоо, 1643 удаагийн нийтийг хамарсан ажлыг зохион байгуулж, нийт 36223 ажилгүй иргэнийг хамруулсан байна.

Дээр дурьдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд 2013 онд нийт 7370 шинэ ажлын байр, 34186 түр ажлын байр ажлын бий болсон байна.

Мөн хөдөлмөрийн зах зээл дэх эрэлтийг нэмэгдүүлэх, иргэдийн аж ахуй эрхлэх, орлого нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжих бодлогыг орон нутагт хэрэгжүүлж байна. Үүнд:

Сум хөгжүүлэх санд 2013 онд 24 тэрбум төгрөгийн санхүүжилт хуваарилж, нэг суманд ногдож буй хөрөнгө оруулалт дунджаар 150 сая төгрөгт хүрсэн. Тус сангаас 2013 онд хүнсний үйлдвэр 1000, хөнгөн үйлдвэр 1696, газар тариалан 951, мал аж ахуй 1215, барилга-497, худалдаа үйлчилгээ 790, бусад-827 нийт 7486 төсөл дэмжигдсэний үр дүнд 7359 шинэ ажлын байр, 1821 түр ажлын байр бий болж, 6840 ажлын байр хадгалагдсан байна. Мөн жижиг дунд, үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээс 64.2 тэрбум төгрөгөөр 627 төсөл дэмжигдэж, 6310 шинэ ажлын байр бий болж 2778 ажлын байр хадгалагдсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих зорилгоор иргэнд 5 хүртэл сая, нөхөрлөл, хоршоонд 10 хүртэл сая төгрөг хүртэлх жижиг зээлийг, сарын 0,85 хувийн хүүтэйгээр банкаар дамжуулан олгож байна. 2013 оны эхний 11 сарын байдлаар 976,5 сая төгрөгийг 336 иргэн, нөхөрлөл, хоршоо авч 1028 шинэ ажлын байр бий болгожээ.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Монголын залуучуудын холбоотой хамтран их дээд сургуулийн оюутан залуучуудыг зуны амралтын хугацаанд их бүтээн байгуулалт болон сум, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах түр ажлын байраар хангаж, орлогыг нь нэмэгдүүлэх зорилготой “Сумын залуус”, “Ажлын гараа” төслүүдийг шинээр хэрэгжүүлэв. Үүнд:

- “Сумын залуус” төслийн хүрээнд 21 аймгийн 278 суманд 1109 оюутан,
- “Ажлын гараа” төслийн хүрээнд 21 аймгийн 21 суманд 315 оюутан 24 жишиг өвөлжөө барьсан
- “Их бүтээн байгуулалт”-ын чиглэлээр авто болон төмөр зам, шинэ барилга, уул уурхайн салбарт 7 багийн 105 оюутан нийт 1529 оюутан залуучуудыг түр ажлын байранд хамруулан 432.0 сая төгрөгийн цалин урамшуулал олгосон байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, үр дүнтэй хүргэх зорилгоор бүх сум, дүүрэгт ажил хайгч, ажил олгогчийг шууд холбох хөдөлмөр зуучлалын мэдээллийн биет болон онлайн сүлжээг нэвтрүүлэхээр ажиллаж, ажил хайгч, ажил олгогчийг шууд холбосон

/2013 оны 12 дугаар сарын 18-ны өдөр, 13.00 цаг, Төрийн ордон, Б-танхим/

харъяалал харгалзахгүй үйлчилгээ үзүүлэх нэгдсэн сүлжээ бий болгосон. Энэ хүрээнд 141 сум, 134 хороонд онлайн мэдээллийн “Е-бирж” байршуулсан бөгөөд уг системд энэ оны 12 дугаар сарын 1-ний байдлаар 42,8 мянган ажил хайгч иргэн, 51917 ажлын шинэ байр, 26089 ажил олгогчийн мэдээлэл бүртгэлтэй байна.

Хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний ур чадвар тэнцвэргүй, ажил олгогчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн ажиллах хүч дутагдалтай байгааг бууруулах зорилгоор хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил олгох, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, ажил олгогч, ажлын байртай холбоход анхаарч ажиллав. Ийнхүү 2012-2013 оны хичээлийн жилд эрэлтэд суурилсан элсэлт зохион байгуулснаар нийт элсэгчдийн дунд барилга, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, байгаль орчин, уул уурхай, мэдээллийн технологи зэрэг мэргэжлийн чиглэлээр элсэгчдийн эзлэх хувь 69% болж, өмнөх жилийнхээс 7.7 пунктээр, насанд хүрэгчдийн эзлэх хувь 31.5 болж, өмнөх жилийнхээс 9.6 хувиар тус тус өссөн. Түүнчлэн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв /МСҮТ/, Политехник коллежиуд 2 мянга гаруй аж ахуйн нэгж, байгууллагатай гурвалсан гэрээ байгуулж, 23.4 мянган мэргэжилтэй ажилтан бэлтгэсний 57 хувь нь ажлын байртай, 16 хувь нь дээд шатны сургуульд элсэн суралцсан, нийт 73 хувь нь ажил, сургуультай болсон байна. Засгийн газраас хэрэгжүүлж буй “Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр”-ийн хүрээнд “Оюу толгой” компаний санхүүжилтээр 7.0 мянга орчим мэргэжилтэй ажилтныг ажил олгогчийн захиалга-гэрээний үндсэн дээр 5 сарын хугацаагаар сургав. Нийт бэлтгэгдсэн мэргэжилтэй ажилтны 80 гаран хувь нь гэрээт байгууллагадаа байнгын ажлын байранд ажиллаж байна.

Шинэчлэлийн Засгийн газрын хувьд иргэдийн амьжиргааны эх үүсвэр болсон цалин хөлс, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэхэдээ бараа бүтээгдэхүүний үнэ огцом өсч, инфляцийн түвшин нэмэгдэн иргэдэд дарамт учруулахаас сэргийлэх бодлогыг барьж байна.

Цалин хөлсний бодлогын хүрээнд зайлшгүй шийдвэрлэж байх, хөдөлмөрийн үнэлэмжийг бодитой нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлдэг гол хүчин зүйлийн нэг нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ бөгөөд Хөдөлмөр-нийгмийн зөвшлийн 3 талт Үндэсний хорооноос сард тооцсоноор 192 мянган төгрөг байхаар шинэчлэн тогтоож, 36 хувиар нэмэгдүүлсэн нь үр дүнд чиглэсэн бодит ажил болсон гэж үзэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн чанарыг тодорхойлох чухал шалгуур болох цалин хөлсний ерөнхий түвшин нэмэгдэж байгаа боловч бага цалинтай ажиллагчид олон байгаа бөгөөд 2013 онд хийсэн “Цалингийн бүтцийн судалгаа”-аар нийт ажиллагсдын 3 хувь нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжсан байна. Ялангуяа баруун бүс нутаг, хөдөө аж ахуй, нийтийн хоолны салбарт бага цалинтай ажиллагчдын эзлэх хувь өндөр байна. “Цалин хөлсний талаар төрөөс баримтлах бодлого”-ыг батлуулан, **салбарын түвшинд** тарифын хэлэлцээрийн зарчмаар цалин хөлсний тогтолцоо, зохицуулалтын зохистой механизмыг бүрдүүлж, 2014 оноос уул уурхай, барилгын салбараас эхлэн хэрэгжүүлэх, **харин аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд** инфляцийн түвшин, ажилтны ур чадвар, бүтээмжтэй уялдуулан цалин хөлсийг нэмэгдүүлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжих бэлтгэл ажил хийгдэж байна.

/2013 оны 12 дугаар сарын 18-ны өдөр, 13.00 цаг, Төрийн ордон, Б-танхим/

Цаашид хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлд тулгарч буй бэрхшээл, хүндрэлийг шийдвэрлэх, үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр анхаарч ажиллана. Тухайлбал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, тулгарч буй бэрхшээл, хөдөлмөрийн зах зээлд орж буй өөрчлөлттэй уялдуулан хөтөлбөрүүдийг шинэчлэх, иргэдийн хөдөлмөрлөх идэвхи санаачилга, ажиллах боломж нөхцөлийг түлхүү дэмжих идэвхитэй бодлогын хүрээг өргөжүүлнэ. Жишээлбэл, сургууль төгсөөд ажилгүй байгаа залуучууд, бага, доогуур орлоготой иргэд, 40-ээс дээш болон ахмад насны иргэдийн орлогыг дэмжих шинэ арга хэмжээг турин нэвтрүүлэх бөгөөд бизнес инкубаци, мэргэжил олгох, давтан сургах арга хэмжээг ажлын байр, бараа бүтээгдэхүүн шйлдвэрлэл, борлуулалтыг дэмжихэд чиглүүлнэ.

Түүнчлэн Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулж буй өнөөгийн харилцаа нь хөдөлмөрийн гэрээгээр хязгаарлагдаж, анхан шатанд нийгмийн түншлэл хөгжих боломж нь хязгаарлагдмал, хөдөлмөр эрхлэлтийн хүрээний суурь зарчим, иргэний хөдөлмөрлөх эрхтэй холбоотой баталгааг бүрэн тусгаагүй, хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх анхан шатны институцийн үүргийг сулруулсан, дагаж гарсан олон дүрэм, журам зэрэг нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байгаа тул хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх хуулийн зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэх, хамрах хүрээг өргөжүүлэх үүднээс холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулж байна.

Хөдөлмөрийн харилцааг боловсронгуй болгох дээрхи арга хэмжээний үр дүнд тогтвортой, эрүүл аюулгүй ажлын байранд бүтээмжтэй ажиллах нөхцөл боломж бүрдэж, дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн зохистой хөдөлмөрийг төлөвшүүлэх, хөдөлмөрийн үнэлэмж бодитой дээшилж, цалин хөлсний хэмжээ нь амьдрал ахуйн хэрэгцээг хангахуйц түвшинд хүрэх суурь нөхцөл бүрдэх болно.

ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ